Зоонозын халдварт өвчний өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

Б.Амгаланбаяр[1,2], О.Нандин-Эрдэнэ[1], Н.Цогбадрах[2]

[1]Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
[2]Зоонозын өвчин судлалын үндэсний төв
Цахим хаяг: amgaa9797@gmail.com, Утас: 99100733

Түлхүүр үг:
Хүний өвчлөл
Сэжигтэй болон батлагдсан тохиолдол
Зоонозын халдвар

Товч утга: 2011-2020 оны байдлаар хүний зоонозын халдвартай хүний өвчлөлийн сэжигтэй 7923 тохиолдол бүртгэгдсэний 2215 (27.9%) нь тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораториийн шинжилгээгээр (Нян судлал, ийлдэс судлал, ELISA, RT-PCR түргэвчилсэн шиннжилгээ) онош батлагдсан байна. Хүний зоонозын өвчлөлийн батлагдсан нийт 93.7 хувийг хачигт халдвар эзэлж байна. Жилд дунджаар хумхаа болон денге өвчний 1-2 тохиолдол голомтот улс орноос Монгол улсад зөөвөрлөгдөн бүртгэгддэг. Тарваган тахал, боом, бэтэг зэрэг нутагшмал зоонозын халдварт өвчин нийт халдварын 6.3% -ийг эзэлж байгаа хэдий ч эдгээр халдваруудын нийгэм эдийн сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйлс болж байна.

Үндэслэл: Монгол улсад сүүлийн жилүүдэд зоонозын шалтгаант халдваруудын төрөл, тоо жилээс жилд нэмэгдэж, архаг явцтай халдварууд зонхилох байрыг эзэлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлэх шаардлага гарч байна. Тухайлбал 2017 онд өмнөх 10 жилийн дунджаас 13.5 дахин, өмнөх оноос 59.4 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй бүртгэгдсэн тул тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нийгмийн эрүүл мэндийн болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хариу арга хэмжээний чиглэлийг тухай бүр тодорхойлсноор үе шаттай бууруулах нь чухал ач холбогдолтой[1,2]. 2019-2020 онд буурсан хэдий ч зоонозын халдварт өвчний үеийн нас баралт, хариу арга хэмжээний зардал болон нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл өндөр хэвээр байна[3]. Иймд тогтмол бүртгэгдэж буй зоонозын халдварт өвчний мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үндэслэл, оновчтойгоор төлөвлөн зохион байгуулах шаардлагатай байна.

Зорилго: 2011-2020 онд бүртгэгдсэн зоонозын халдвартай хүний өвчлөлийн статистик тоон мэдээнд дүн шинжилгээ хийх;

Зорилт:

1. 2011-2020 онд бүртгэгдсэн тарваган тахал, боом, галзуу, хачгаар дамжих 3 төрлийн халдвар, бэтэг, хумхаа зэрэг зоонозын халдварын хүний өвчлөлийн статистик тоон мэдээнд дүн шинжилгээ хийх;
2. Зоонозын халдвартай хүний өвчлөлийн дүн шинжилгээнд үндэслэн зөвлөмж боловсруулах;

Судалгааны арга аргачлал: Энэхүү судалгааг дескриптив судалгааны аргаар хийж гүйцэтгэж, мэдээ мэдээллийг EPI INFO, SPSS програм ашиглан боловсруулсан.

2011-2020 онд Зоонозын өвчин судлалын үндэсний төвд бүртгэгдсэн зоонозын халдварын хүний өвчлөлийн 7923 тохиолдлын тархвар судалгааны хуудас, анхан шатны бүртгэл маягтыг ашиглан мэдээллийг боловсруулсан.

Үр дүн: 2011-2020 онд зоонозын халдварт өвчний 7923 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, 2215 (27.9%) нь тархвар судлалын холбогдол, эмнэл зүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр онош бүрэн баталгаажсан байна. Зоонозын халдварт өвчний батлагдсан тохиолдлын 93.7% (n=2075)-ийг хачгаар дамжих халдварт өвчин (Х.риккетсиоз, Х.энцефалит, Х.Боррелиоз) буюу нутагшмал хэлбэрээр дамжуулагчаар дамжин хүнд халдварлах халдварт өвчлөл эзэлж байна. Зөөвөрлөгдсөн халдваруудаас хумхаа жилд дундажаар 1-2 тохиолдол бүртгэгдэж

байна. Нутагшмал хэлбэрээр зонхилон тохиолдох зоонозын халдварт өвчин болох тарваган тахал, боом, бэтэг зэрэг халдварууд нийт халдварын 6.3%-ийг эзэлж байна. (Зураг 1.)



Зураг 1. 2011-2020 онд бүртгэгдсэн зоонозын халдварын хүний өвчлөлийн төрөл тус бүрээр харьцуулсан үзүүлэлт

Зоонозын халдварын сэжигтэй тохиолдлын 40.1 хувь нь малчид байна. Насны ангиллаар судалж үзэхэд нийт тохиолдлын 49.5% нь эд хөдөлмөрийн насныхан буюу 18-40 насныхан эзэлж байна.



Зураг 2. Зоонозын халдварын хүний өвчлөлийн өсөлтийг тохиолдлын түвшингээр харьцуулсан үзүүлэлт

Зоонозын халдварын хүний өвчлөлийн батлагдсан тохиолдол 10.000 хүн амд 0.71, хүн амын дунд 221 тохиолдол бүртгэгдэж байна. 2014 оноос огцом өсч, 2017 онд оргил үедээ хүрсэн бөгөөд 2018 оноос буурах хандлагатай байна. (Зураг 2).

Хэлцэмж: 2004 онд Байгалийн голомтын халдварт өвчин судлалын үндэсний төвийн судлаачид болох Д.Отгонбаатар[4] нарын Монгол дахь зоонозын өвчний байгалийн голомт, хүний өвчлөлийн төөрөглөл тооцоолох судалгаагаар цаашид байгалийн голомтод халдварт өвчин халдвар хүн амын дунд өсөх хандлагатай байна гэж үзжээ. Харин 2011-2020 оны Зоонозын халдвартай хүний өвчлөлийн тохиолдлыг авч үзэхэд 2017 онд оргил үедээ хүрч, 2018 оноос буурах төлөвтэй байна[5]. Энэ нь эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлж, нийгмийн эрүүл мэндийн болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зөв зохион байгуулж, хариу арга хэмжээний чиглэлийг тухай бүр тодорхойлсноор үе шаттай буурч байгаа төлөв ажиглагдаж байна.

2016 онд ЗӨСҮТ-ийн Б.Уянга нарын хийсэн судалгаа болох хачигт халдварын төлөв байдлыг гаазрзүйн бүслүүрээр ангилан үзэхэд уулын тайгын бүслүүрт хүний өвчлөлийн 57% нь бүртгэгдэж, 10000 хүн ам дахь тохиолдол болон хүн амын халдваржилтын хувь хамгийн өндөр, мөн хоёр зүйл хачигт халдваржилт хамгийн өндөр хувиар илэрч байсан нь бидний судалгааны үр дүнтэй (93.7%) нийцэж байна[6].

2011-2020 онд бүртгэгдсэн зоонозын халдвартай тохиолдлуудын 49.5% нь эд хөдөлмөрийн насныхан буюу 18-40 насныхан эзэлж байна. Энэ нь халдвар хүндрэл ихтэй бэтэг, хачигт энцефалит зэрэг өвчлөлийн хөдөлмөрийн чадвар алдах, нийгэм эдийн засгийн хүчин зүйлд сөргөөр нөлөөлж байна[8].

Дүгнэлт: 2011-2020 онд бүртгэгдсэн зоонозын халдвартай хүний өвчлөлийн батлагдсан тохиолдлууд нь өмнөх 10 жилтэй харьцуулахад 4.3 дахин өссөн байна. Иймд цаашид зоонозын халдваруудын судалгаануудыг үе шаттай хийх, нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ, интервенцүүдийг тасралтгүй зохион байгуулах шаардлагатай байна.

Талархал: Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд мэдээллээр хангасан Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хамт олон, арга зүйн зөвлөмжөөр хангасан АШУҮИС-НЭМС-ийн Эпидемиологи, биостатистикийн тэнхимийн хамт олон, удирдагч багш Анагаах ухааны доктор О.Нандин-Эрдэнэ, Зөвлөх Анагаах ухааны доктор, дэд профессор Н.Цогбадрах нарт гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *ЗӨСҮТ. 2021. Зоонозын халдварт өвчний тандалтын мэдээ. https://nczd.gov.mn/?p=11036*
2. *Зоонозын халдварын тулгамдсан асуудал, олон улсын эрдэм шинжилгээний 22 дугаар хурлын эмхэтгэл*
3. *Зоонозын халдварын тулгамдсан асуудал, олон улсын эрдэм шинжилгээний 23 дугаар хурлын эмхэтгэл*
4. *Монгол дахь зоонозын өвчний байгалийн голомт, хүний өвчлөлийн төөрөглөл, Д.Отгонбаатар*
5. *ЗӨСҮТ-ийн 2011-2020 оны статистик эргэн мэдээлэл*
6. *Монгол улсад бүртгэгдсэн хачигт энцефалитын тархвар зүйн онцлог, 2005-2016, Б.Уянга*
7. *Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл, 2017 №5 (76)*
8. *International scientific conference "Current issues on zoonotic diseases" Ulaanbaatar 2011*
9. *Эрдэм шинжилгээ судалгаа бүтээлийн товчоон Д.Отгонбаатар, 2010 он*

Current situation of zoonotic diseases

Amgalanbayar B[1,2], Nandin-Erdene O[1], Tsogbadrakh N[1]

[1]Mongolian National University of Medical Sciences
[2]National Center for Zoonotic Diseases
Email: amgaa9797@gmail.com, Tel: 99100733

As 2011-2020, 7923 suspected cases of human zoonotic diseases were reported, 2215 (27.9%) of them were confirmed. All confirmed human cases diagnosed by laboratory (Bacteriology, ELISA, RT-PCR test, rapid tests). A total of 2075 confirmed cases of human zoonotic diseases are tick-borne diseases (TB. rickettsiosis, TB. Encephalitis and TB. borreliosis) or communicable diseases that transmitted to humans through localized transmission. On average, 1-2 cases of malaria and dengue transmitted from endemic countries to Mongolia in every year. Endemic zoonotic diseases, such as plague, anthrax, and echinococcosis, account for 6.3% of all infections, but the socio-economic impacts are high due to factors such as the cost of socio-economic response.

Key words: human diseases, suspected and confirmed cases, zoonotic infection